

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төслийн тухай товч танилцуулга	2
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	2
1.3. Баяжуулах үйлдвэрийн байршил.....	2
1.4. Төслийн хүчин чадал.....	4
1.5. Төслийн технологи	5
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	6
2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	6
2.2. Байгаль орчин	7
2.2.1. Уур амьсгал.....	7
2.2.2. Агаарын чанар	7
2.2.3. Гадаргын ус.....	8
2.2.4. Газрын доорх ус.....	8
2.2.5. Хөрсөн бүрхэвч	8
2.2.6. Ургамлын орчны нөхцөл.....	9
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	10
4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
4.1. Агаар орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ	13
4.2. Хөрсөн орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ	13
4.3. Усан орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ .	15
5. хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
6. эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
7. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
9. дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	21
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
12. Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	24
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	25

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тухай товч танилцуулга

Төслийн нэр: “Жонш баяжуулах үйлдвэр”

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага: “Хэрлэн-Импэкс”; Улсын бүртгэлийн дугаар: 9019073096; Регистрийн дугаар: 2009765;

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:


Дорноговь аймаг Айраг сум, 4-р баг, Цагаан Дөрвөлж, ТЗ-ын өртөө.

1.3. Баяжуулах үйлдвэрийн байршил

Газар зүйн байршил: Төслийн байршил нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт “Өмнөд-Алтат”-ын жоншны ордын талбайд буюу байр зүйн зургийн L-49-75 хавтгай дээр Хайртын уурхайн зүүн талд оршиж байна.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн солбилцол

Талбайн булангийн цэгүүд	Х	У
1	109° 23'56.73"E	45°45'26.62"N
2	109° 23'9.28"E	45°45'26.62"N
3	109° 23'9.28"E	45°45'36.62"N
4	109° 23'56.73"E	45°45'36.62"N



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн агаар сансрын зураг



Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн зохион байгуулалтын зураг/дрон/

1.4. Төслийн хүчин чадал

Баяжуулах үйлдвэр нь нэг давхар шаталсан хэлбэрээр баригдсан бөгөөд энэ нь бүтээгдэхүүн өөрийн урсгалаар процесст тээвэрлэгдэж, дотоод тээвэрлэлтийн төхөөрөмжийн хэрэглээг бууруулна гэж үзсэн байна. 2022 оны ТЭЗҮ-д тооцсоноор жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал нь 80.0 мян.тонн байх бөгөөд үйлдвэр нь үндсэн гурван нэгж хэсгээс бүрдэж байна. Үүнд:

1. Баяжуулах үйлдвэр

- a. Хүдэр хүлээн авах, хольж жигдрүүлэх талбай
- b. Хүдэр бутлах цех
- c. Гол корпус (ангилян -нунтаглах хэсэг, флотаци, урвалжийн хэсэг,)
- d. Өтгөрүүлэлт, шүүх цех (вакум фильтр)
- e. Баяжмалыг савлан тээвэрлэх цех
- f. Бэлэн баяжмал хадгалах талбай
- g. Худаг
- h. Дизель станц
- i. Пүүлэгч
- j. Химийн бодисын агуулах
- k. Автомашин, техник хэрэгслийн ил зогсоол

2. Хаягдлын сан

- a. Шингэн хаягдлын урьдчилсан цооног
- b. Котел технологийн ус халаах хэсэг
- c. Цөөрөм

3. Оффисын барилга


- a. Ажилчдын амрах байр
- b. Гал тогоо
- c. Оффис
- d. Лаборатори

Хүснэгт 2. Баяжуулах үйлдвэрийн ажлын горим

Д/д	Үзүүлэлтүүд	Тоон утга
1	Өдөрт ажиллах бодит цаг	20
2	Жилд ажиллах сар	7
3	Жилд ажиллах бодит цаг	3960
4	Жилд ажиллах хоног	210
5	Цагийн хүчин чадал, тн/цаг	11.4
6	Хоногийн хүчин чадал тн/цаг	416.6
7	Сарын хүчин чадал тн/сар	12498.0
8	Жилийн хүчин чадал тн/цаг	80000

1.5. Төслийн технологи

Флюоритын эрдсийг хоосон чулуулгаас салгаж, 97%-ийн агуулгатай баяжмал гаргахын тулд цуглуулагч урвалжаар тосны хүчил, дарагч урвалжаар шингэн шил, булингын орчин тохируулагчаар техникийн сод зэрэг химийн бодис урвалж ашиглах бөгөөд үүнд гурван шатны бутлалт, 2 шатны нунтаглалт хийж үндсэн, хяналтын, цэвэрлэгээний флотацийн цикл шат дамжлагуудыг хэрэглэн жоншны ФФ-97 маркийн баяжмал гаргаж авна.



Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Төслийн талбай нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах ба тус бүс нь газрын гадаргын хувьд намхан толгод, хотгор хотос, цав толгод бүхий ухаа гүвээ ээлжлэн солигдох бөгөөд талбайн зүүн болон зүүн хойд хэсгээр ерөнхийдөө зүүн хойноос баруун урагшаа чиглэлтэй намхан уулс, дов толгодорхог гадаргуутай байхад талбайн өмнөд болон баруун өмнөд хэсгээр уулс хоорондын хотгор бүхий жижиг хөндий байна.

Айраг Өртөө Улаанбаатар Төмөр замын харъяа Айраг Өртөө Цагаандөрвөлж багт, 3-р хороонд байрладаг. 1953 онд төмөр зам тавигдаж ашиглалтанд орж, 1964 онд өртөө болон өргөжсөн. Доноговь аймгийн Айраг сум нь 744258 га газар нутагтай. Үүнээс: Хөдөө аж ахуй, бэлчээрийн 705557 га, тусгай хэрэгцээний газар 29012 га, , хот суурин бусад суурин газар 4131 га, усан сан бүхий 1044 га талбай эзэлдэг.

Хүн ам зүйн

Нард, Сайн ус, Нүдэн, Цагаандөрвөлж гэсэн 4 багийн нийт 1112 өрхөд 3590 хүн амтай. Хүн амын 98% халх үндэстэн амьдардаг. Баруун талаараа Дундговь аймгийн Өндөршил, зүүн хойд талаараа Хэнтий аймгийн Дархан сум, бусад талаараа өөрийн аймгийн Даланжаргалан, Иххэт, Алтанширээ, Сайхандулаан сумдтай хиллэдэг. Төслийн талбайн нийгэм эдийн засгийн байдал: Төслийн талбай орчимд нутгийн оршин суугчдын өвөлжөө, хаваржаа байх боловч тусгай зөвшөөрлийн талбайтай давхардсан айлын газар байхгүй.

Хөдөө аж ахуй

Сумын хэмжээгээр нийт 111232 толгой мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 15600 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 14 хувь байна. 282 малчин өрх, 262 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 49 хувийг эзэлж байна. Сумын хэмжээгээр жилд 1,5 га талбайд төмс, 1,72 га талбайд хүнсний ногоо тариалж 21,0 тонн төмс, 30,0 тонн хүнсний ногоо, хураан авсан байна.

Сумын хэмжээгээр нийт 111232 толгой мал тоологдсоноос адуу 6877, үхэр 2857, тэмээ 888, хонь 43109, ямаа 38197 байгаа бөгөөд цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 15600 толгой мал тоологдсон нь нийт малын 16,9 хувь байна. 253 малчин өрх, 347 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 54 хувийг эзэлж байна.

Хөнгөн, хүнсний аж үйлдвэр

2013 онд аймгийн хөрөнгө оруулалтаар 261,0 сая төгрөгний өртөгтэй Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв барьж шинээр оёдолчин, гуталчиний иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулсан ашиглалтанд оруусан. Үүнээс гадна:

- “Сайн” кимчи, даршилсан ногоо 1
- Бэлэн гурил 1
- Нарийн боовын 1
- Модон эдлэлийн үйлдвэрлэх цех 1 үйл ажиллагаа эрхэлж байна.

Эрчим хүч, барилгын материалын аж үйлдвэр

Сумын төвд 2 төвлөрсөн уурын зуух ажиллаж дулааны хэрэгцээгээ хангаж байна. Сумын төв дээр 110/35/10кВт-ын цахилгаан дамжуулах Дэд станцтай. Блок үйлдвэрлэж, шар шавар өрлөг хийхэд ашигладаг.

1984 онд баригдсан. Цагаандөрвөлж 1 хороонд байрладаг 9 хүний оронтоотой ажилдаг. Цахилгаан эрчим хүч дамжуулах үйл ажиллагаа эрхэлдэг. Цахилгаан халаагууртай Жилд 65- 70 сая кВт/ цаг цахилгаан эрчим хүчийг дамжуулдаг. Суурьлагдсан хүчин чадал нь 12.6 мВт хүчин чадалтай.

Зам харилцаа

Сумын газар нутгаар ОХУ, БНХАУ - ыг холбосон олон улсын чанартай төмөр зам, мөн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Орон нутгийн иргэд, ААНБ - ууд суудлын болон ачааны 500 орчим авто машин байнгын хөдөлгөөнд оролцож байдаг. Босоо тэнхлэгийн замаас салаалсан сумын төвд 1,7 км урттай хатуу хучилттай замтай. Багууд хоорондоо шороон замаар холбогддог. Монгол Оросын хувь нийлүүлсэн Төмөр замын зангилаа байрлаж нийт 110 гаруй ажилтантай 9н анги, салбар нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

2.2. Байгаль орчин

2.2.1. Уур амьсгал

Тус төсөл хэрэгжих газар нутаг нь Монгол улсын бусад газар нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалын бүсэд байрлана. Төсөл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэрийн агаарын жилийн дундаж температур 3.5 – 3.7°C байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур 23.1 – 24°C юм. Тус нутгаар 36.3 – 40.2°C-ийн үнэмлэхүй хамгийн их температур 5 %-ийн хангамжтай буюу 20 жилд 1 удаа тохиолдоно. Жилийн хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур –15.3°C байна. Үнэмлэхүй хамгийн бага температур –41.4 – 41.5°C хүйтэрсэн байна. Төсөл хэрэгжих талбай орчмоор анхны цочир хүйтрэлт 9-р сарын 17-ны үед эхлэн, 5-р сарын 23-ны үед дуусна. Монгол орны хувьд агаарын температурын жилийн дундаж сүүлийн 30 орчим жил 1.9°C-аар дулаарсан бол өмнө ба зүүн бүсэд 1.5-1.6°C, баруун ба төвийн бүсэд 2.0 - 2.3°C-аар тус тус дулаарчээ. Дулааралт хүйтний улиралд илүү их ажиглагдаж байгаа бөгөөд өвлийн улиралд агаарын температурын дундаж 3.6°C, хавар намрын улиралд 1.4-1.9°C-аар нэмэгдсэн байна.

2.2.2. Агаарын чанар

Жонш баяжуулах үйлдвэр байрлаж буй Айраг сумын 4 дугаар багийн нутагт орших бөгөөд хөдөө тал нутгийн агаарын бохирдолгүй, дуу чимээгүй, нунтаг ширхэглэлтэй тоосгүй хэсэг юм. Баяжуулах үйлвэрийн хаягдлын далан, усан сан, хаягдлын шаламаас үүсэх нарийн ширхэгт цагаан тоос үүсэх магадал их байна. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байдаг.

2.2.3. Гадаргын ус

Судалгааны талбай түүний дүүрэг нь усан хангамж сайтай, ус зүйн үүднээс Номхон далайн ай сав, Умард говийн гүвээт-Халхын говийн сав газарт тус тус багтана. Цөөн тооны булаг нь гадаргад хагарлын бүсээр хянагдсан булгуудаар тэжээгдэх бөгөөд зуны улиралд буух хур тунадасны хэмжээтэй шууд холбоотой. Ихэнх хур тунадас 7-8-р сард бороо хэлбэрээр орно. Түр зуурын урсац бүхий цөөн тооны гол дулааны улиралд хур багатай жил шургаж усгүй сайрууд болдог. Судалгааны талбай орчимд байнгын устай гадаргын ус байхгүй. Районы хэмжээнд хур тунадасаар тэжээгддэг хужир, мараалаг, давсархаг шал тойрмууд цөөн тоогоор бий.

Газар нутгийн нийт чийгшил 250 мм -ээс дээш, усны гадаргаас уурших ууршилт 400-600 мм бөгөөд гол мөрний усны горим нь хаврын шар ус, зуны хурын усаар тэжээгддэг ба үүнээс газар доорхи усаар 20%, цасны усаар 25%, хурын усаар 55% тэжээгдэнэ. Голын хатуу урсацын жилийн хэмжээ 1-2 тн/км , голын усны булингаршил нь 100-200 г/м3 байна. Борооны үерийн хамгийн их урсацын модуль нь 0.2-0.4 км2 л/с байгаа нь дунд зэргийн үзүүлэлт юм.

2.2.4. Газрын доорх ус

Судалгааны талбайн газрын доорх усны онцлогийн талаар бичихдээ “Дунар-Од” ХХК- ийн 2010-2012 онд гүйцэтгэсэн “ӨМ-Дорнодын хэсэг орчмын гидрогеологийн 1:200000- ны зураглалын ажил зэрэг бусад материалаас үзэхэд төслийн талбай нь геологийн нийлмэл тогтоцтой, янз бүрийн нас, найрлагын гүний биетүүдээр зүсэгдсэн, хагарлын системүүдээр хэрчигдсэн блоктор бүтцийг бий болгосон байна. Мөн түүнчлэн физик газарзүйн нөхцлийн гол онцлог нь эрс тэс эх газрын уур амьсгалтай, унах хур тунадасны хэмжээ бага, ууршилт нь хур тунадаснаасаа давдаг, байнгын урсацтай гадаргын ус байхгүй, гадаргын хувьд үндсэндээ нэгэн хэвийн буюу уулс хоорондын том, жижиг хотгор, хотос бүхий намхан бэсрэг уул, толгодтой юм. Эдгээр хүчин зүйлүүдээс хамааран газрын доорх усны байрлал, усан сүлжээ, тэжээгдлийн нөхцөл, химийн найрлага, тэдгээрийн тоо хэмжээ нь янз бүр байна.

2.2.5. Хөрсөн бүрхэвч

Монгол орны хөрсөн бүрхэвчийн ангиллаар тус талбайн Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн Баяндэлгэрийн тойрогт хамаарагдана /Монгол улсын үндэсний атлас, 2009/. Судалгааны талбай нь хуурай хээрээс заримдаг цөлийн бүсэд шилжих шилжилтийн бүсэд орших учраас хөрсөн бүрхэвч нь хүрэн шороон хөрснөөс заримдаг цөлийн хөрс хүртэлх шинж чанарыг агуулдаг.

Судалгааны талбай нь цайвар хүрэн хөрсний тойрогт хамаарах боловч Монгол орны хөрсний ангиллаар заримдаг цөлийн бор хөрстэй нутаг юм. Ийм учраас байгалийн бүсийн онцлог, заримдаг цөлийн бор хөрсний үндсэн шинж судалгааны талбайн хөрсөн бүрхэвчийг тодорхойлно. Академич Д.Доржготовын тодорхойлсноор судалгааны талбай орчмын хөрсний онцлог, байгалийн үндсэн хэв шинж зэргийг тодорхойлсныг энд оруулсан болно. Энэхүү үр дүнг өөрсдийн хээрийн судалгааны үр дүнтэй харьцуулан дүгнэлт гаргасан.

Заримдаг цөлийн бүсийн үндсэн хэвшинжийн хөрс болох говийн бор хөрсний тухай анхны судалгааг Б.Б.Полынов (1930) хийсэн бөгөөд түүнээс хойш олон судлаачид (Андреев, 1935, Беспалов, 1951, Соколовский, 1960, Кокорин, 1968, Умаров, Якунин, 1974, Ногина, Евстифеев, Уфимцева, 1977, Рубцова, 1978 болон бусад) энэ хөрсний талаар өөрсдийн бүтээлд дурьдсан байдаг. Бид энэ хөрсийг анх 1968 онд Нууруудын хөндий, Их Нууруудын хотгороор аялахдаа судалж эхэлснээс хойш хангалттай материал хуримтлуулсан юм.

Заримдаг цөлийн бор хөрс говийн хялгана, говийн хазаар өвс, таана, хөмүүл, баглуур, бударгана голлосон цөлөрхөг хээрийн ба хээржүү цөлийн ургамалшил бүхий цав толгодот тал газар, уулсын хоорондох томоохон хотгор, хөндий хоолойг хамарч улсын бүх нутгийн 12.9%-тай тэнцэх хэмжээний талбайг эзлэн тархах бөгөөд түүний дээрх ургамлын бүрхэц даан ч сийрэг (8-10%-иас 20-25% хүртэл) тул цулгуй нүцгэн газар их байна. Газрын дээрх ургамлын биомассын хэмжээ хуурай жил 0.6-1.3 ц/га, чийгтэй жил 1.8-3.5 ц/га хүрдэг бол газар доорх ургамлын үндэсний масс газрын дээрх хэсгээсээ хуурай жил 120 дахин, чийгтэй жил 50 дахин их байдаг ажээ (Гордеева, 1974; Казанцева, 1986; Даваажамц, 1974). Говийн бор хөрсний гадарга дээрх элс-сайр чулуун хучаас хэдий зузаан биш (0.5-2 см) ч гэсэн хөрсний дулааны горимд тодорхой хэмжээгээр нөлөөлж хөрсний өнгөн хэсгийг хэт халалтаас хамгаалдаг онцлогтой.

2.2.6. Ургамлын орчны нөхцөл

Энэ нь нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евразийн хээрийн их мужийн Төв азийн Алтанширээгийн тойрогт хамаарна.

Ургамалжилтын хувьд сөөг, сөөглөг, сөөгөнцөрлөг ургамал дээд дэд, олон наст өвслөг ургамал дунд дээд, нэг наст ургамлын өнгөрсөн жилийн босоо хагд өвст хэвшил тохиолдоно. Талбайн орчим бэлчээр нутаг нь жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой ба ялангуяа намрын бэлчээрт ашиглахад илүү тохиромжтой бэлчээрийн газар. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь sor1-sp, бусад зүйл ургамлууд нь sol үнэлгээтэй. Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг олон наст өвслөг болон сөөглөг, сөөгөнцөрлөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингыг олон наст ургамлын хагд ба борог өвс бүрдүүлж байна.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” -ын дагуу боловсруулсан болно.

2024 оны БОМТ-ний биелэлтийг орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт 2025 оны 06-р сарын 24-ны өдөр 90.3%-ийн дүгнэгдсэн. Иймд 2025 оны БОМТ-нд орон нутгаас өгсөн саналын дагуу дараах ажлуудыг оруулав.

Хүснэгт 3. Орон нутгийн ажлын хэсгийн санал

№	Орон нутгаас өгсөн санал	Орон нутгаас өгсөн саналын дагуу хэрэгжүүлэх ажлууд
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үйлдвэрийн онцлогт тохируулан бодитой төлөвлөж, сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч, үр дүнг тоо баримттай тайлагнах	Баяжуулах үйлдвэр нь жил бүр БОМТ үйлдвэрийн онцлогт тохируулан бодитой төлөвлөдөг ба биеэлэлтийн тайланд сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулсан үр дүн тоо баримттай тайлагнаж ажилладаг.
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний 58 дугаар зарлигийн дагуу “Тэр бум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцож тайлан мэдээ ирүүлэх	“Тэр бум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд баяжуулах үйлдвэрийн хашаанд 2025 оны хавар мод тарьж ажилласан.
3	Орчны хяналт шинжилгээг тогтмолжуулан хяналт тавин жил жилээр харьцуулан дүн шинжилгээ хийх, тодорхойлохоор тусгагдсан үзүүлэлтүүдийг бүрэн хийлгэж байх, стандартаас давсан үзүүлэлттэй газруудад арга хэмжээ авах	ОХШХ-тусгав
4	Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ /БОХ-3 маягт/-г үнэн зөв бодитой гаргаж дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор сумын ЗДТГ-т хүргүүлэх	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгав
5	Хүн амын унд ахуйд ашиглаж байгаа усанд улирал тутам 1 удаа, жилдээ 4 удаа шинжилгээ хийлгүүлж байх	ОХШХ-тусгав
6	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хаягдал ус хаяж зайлуулах цэгийн зөвшөөрөл авах, дүгнэлт гаргуулж гэрээ байгуулан ажиллах	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгав
7	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмын дагуу худаг, уст цэгүүд, усны эх үүсвэр тус бүрийг тоолууржуулах, ус хангамжийн эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн бүс тогтоох, ус ашиглалтын тайланг тайлант онд багтаан ирүүлнэ	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгав
8	Хог хаяглын цэгийн хуульд заасан шаардлагын дагуу байгуулах	2025 онд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын цэгийг байгуулахаар тусгав.
9	Аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	Аюултайг хог хаягдал болох ашигласан тос масло болон химийн бодисын үлдэгдэл болон сав баглаа

		боодлыг аюултай хог хаягдал устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэн ажиллана.
10	Аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад шилжүүлэх хүртэл түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд, хуулийн хугацаанд хадгалах	Аюултай хог хаягдал хадгалах цэгт хадгална.
11	Ан амьтдын байршил, тархалт тоо толгойг тогтоон төслийн үйл ажиллагаанаас учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн Засаг захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Орон нутгийн Засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллана.
12	Уул уурхайн үйлдвэрийн бүс дотор болон төвийн цахилгаан шугамаас уурхайн чиглэлд татсан өндөр хүчдэлийн цахилгаан шон дагуу шувуу үргээгч байршуулах	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгав.
13	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтөлж байх /MNS 4219-94/	2025 оны БОМТөлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.
14	Байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлыг нөлөөллийн бүсийн оршин суугчид, иргэд, сум, багийн ИНХ-д танилцуулж баримтжуулан тайланд хавсаргаж байхыг мэдэгдье	Нөлөөлийн бүсийн оршин суугчдад 4-р улиралд өвс тэжээл олгох үед БОМТ биелэлтийн тайланг танилцуулан ажилладаг.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Агаар орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ

№	Агаар орчинд үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж Хугацаа	Хянах үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө мян.төг	
						Нэгж зардал	Нийт
1	Хүдэр жигдрүүлэх талбай	Хүдэр жигдрүүлэлт дээр ажиллаж буй ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Хүдэр жигдрүүлэх талбай	1 жилд 2 удаа	MNS 5621: 2006	6,000	12,000
2		Салхины хурд ихтэй үед ажиллахгүй байх		Тогтмол	Агаарын тухай хууль	-	-
3	Тээвэрлэлтийн шороон зам	Шороон зам дагуу тэмдэг, тэмдэглэгээ хийх	Тээвэрлэлтийн шороон зам		Агаарын тухай хууль, Хөрс хамгаалал, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	500.0	500.0
4	Болзошгүй аюул, ослын үед хорт хий ялгарч, агаарын чанарт нөлөөлөх	Химийн бодисын хаягдал үлдэгдлийг үйлдвэрлэлийн хаягдал материал устгахад мэргэшсэн мэргэжлийн байгууллагаар устгуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Тогтмол		-	-
5		Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдэд учирсан гэмтлийг цаг тухай бүр янзалж, дотоод шаталтын хөдөлгүүрийг засварлаж байх		Тогтмол	Агаар орчныг бохирдуулах, хорт утаа ялгаралтыг бууруулна	-	-

4.2. Хөрсөн орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ

№	Газрын гадрага, Хөрсөн орчинд	Урьдчилан сэргийлэх болон бууруулах	Хамрах хүрээ	Давтамж Хугацаа	Хянах үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө мян.төг
---	-------------------------------	-------------------------------------	--------------	-----------------	----------------	----------------------------

	үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл	арга хэмжээ				Нэгж зардал	Нийт
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх сөрөг нөлөөлөл	Тээврийн хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засаж тохижуулах	Үйлдвэрийн Талбайд	Тогтмол	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засаж тохижуулсан байна	2,000.0	2,000.0
2	Химийн бодис тээвэрлэх, түгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа шаардлагын дагуу зөв явагдаагүйгээс химийн бодис хөрсөнд алдагдаж, хөрс бохирдуулах	Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, газруудын шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийх.	Агуулах	-	-	-	-
3		Хөрсөн орчинд химийн бодис алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шуурхай шингээн авах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Ослын үед	Асгаралтын үед ашиглах шингээгч материалыг бэлэн байлгах	1,000	1,000
4		Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Төслийн нийт талбайн хэмжээнд	Тогтмол	Байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх	-	-
5		Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтад байнгын хяналт тавих	Төслийн нийт талбайн хэмжээнд	Тогтмол	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтад байнгын хяналт тавьж	-	-

					ажиллана.		
--	--	--	--	--	-----------	--	--

4.3. Усан орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ

№	Усан орчинд үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж Хугацаа	Хянах үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө мян.төг	
						Нэгж зардал	Нийт
1	Усан орчинд үзүүлэх нөлөөлөл ямар байгааг хянаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт төлөвлөн хэрэгжүүлэх замаар сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Ашиглагдаж, хадгалагдаж байгаа бодисуудын сав баглааны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж байх ёстой.	Төслийн нийт талбайн хэмжээнд	Тогтмол	-	-	-
2		Усан орчны хяналт шинжилгээг тогтмол хийх		Жилд 2 удаа	Орчны хяналт шинжилгээг тухай бүрт хийлгэсэн байна. Зардлыг ОХШХ-т тусгав.	-	-
3	Химийн бодис алдагдаж, усны урсцын голдиролд орох, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Гүний худгийг хамгаалах зорилгоор худагийг байшин байгуулах	Гүний худгууд	2025 он	-	1,000.0	1,000.
4		Үйлдвэрлэлийн аль ч үе шатанд цэвэрлээгүй бохир усыг байгаль орчинд хаяхгүй байх арга хэмжээг зохион байгуулж ажиллах	Төслийн нийт талбайн хэмжээнд	Тогтмол			

5	Ус ашиглах боломжит нөөцийн тооцоонд тусгагдсаны дагуу ариг гамтай ашиглах	Тоолуурын баталгаажуулалтын цаг тухай бүрт нь хийлгэх, тоолуур эвдрэл гэмтэл гарсан тухай бүр солих	Баяжуулах үйлдвэрийн гүний худаг	Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд	-	500.0	500.0
Нийт зардал						20,000.0	

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөн нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах	Баяжуулах үйлдвэрээс гарах хатуу хог хаягдал Гэрээний дүнгээр			Хог хаягдлын тухай хууль, ангилан ялгаж хаях журам, дотоод дүрэм журам
	Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх				
	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан цуглуулах, хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулах	Үйлдвэрээс гарах ахуйн хатуу хог хаягдал	4,000.0		
Хаягдал ус	Ахуйн бохир усны цооногт ариутгах, халдваргүйжүүлэх.	Бохир усны цооног	500.0		
Аюултай	Ашигласан тос масло хадгалах цэгийн бүрэн бүтэн байдлыг хангах	Ашигласан тос масло хадгалах цэг	Үйл ажиллагааны зардалд тусгасан		Хог хаягдлын тухай хуулийн 5- р бүлэг 23- р зүйл
	Аюултай хог хаягдал үйлсгэгчийн дугаар авах	Төслөөс үүсэх аюултай хог хаягдал	-		
	Ашигласан тос маслийг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Тээврийн хэрэгслээс үүсэх ашигласан тос масло	Гэрээний дүнгээр (Клийн Ойл ХХК)		
	Химийн бодисын шингэн үлдэгдэл болон сав баглаа	Химийн бодисын хэрэглээнээс үүсэх	-	1,000.0	

	боодлыг тусгай цэгт түр хадгална.	химийн бодисын үлдэгдэл			
	Химийн бодисын шингэн үлдэгдэл болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Гэрээний дүнгээр (Элемент ХХК / Цэцүүх трейд ХХК)			
Нийт			15,500.0		

6. ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<i>Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>						
1	Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох,	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Үйл ажиллагааны зардалд тусгасан		2025 он	MNS 4990:2000
2		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх			2025 он	MNS 4969:2000
3		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах			2025 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

4		Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилготой анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулж тогтмол дүүргэж байх	Анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулсан байна.	144.0	Тогтмол	тухай хууль, 15-р зүйл
<i>Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>						
4	Хүчтэй салхи шуурганаас аюул, осол гарах	Хүчтэй салхи, шуурга үед аян замд гарахгүй	Төслийн талбай болон түүний ойр орчимд	ҮАЗ	2025 он	
5		Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах	Үйлдвэрийн ажилчид	ҮАЗ		
6	Гал түймрийн улмаас үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал унтраах багаж хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр байрлуулах, галын хорны даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах	Үйлдвэрийн байр сууц	ҮАЗ		Гамшгаас хамгаалах тухай хууль
7		Галын дүгнэлтийг мэргэжлийн байгуулгаар гаргуулах		30,000		Галын аюулгүй байдлын тухай хууль

8		Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажилчдын дунд сургалт явуулах	Нийт ажилчдад	100.0	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсдын дунд жил бүр 1 удаа сургалт явуулна.	
Нийт зардал:				7,821.3		

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад тус сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

9. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Зардал /төг/
2	“Шинэ Айраг хөгжил” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн нийтийн эзэмшлийн зам талбай дагуух ногоон байгууламж тарих хашаалах үйл ажиллагаанд оролцох	Дулааны улиралд	20,000,000
Нийт зардал			20,000,000

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт- шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар				
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TPS, PM2.5, PM10, SO2, NO2	Ажилчдын байр Үйлдвэрийн бүс Хаягдлын далан	Жилд 2 удаа	500,000	Дээжлэхдээ MNS 4585:2007, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
Гадаргын болон газрын доорхи ус				
Гүний худгийн усны чанар: pH, TDS, нийт хатуулаг, ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni,	Гүний худаг	Улиралд 1 удаа	180,000	MNS (ISO) 5667- 5:2001- усны чанар- дээжлэлт
Ахуйн бохир усны цоонгийн бохир ус: pH, Ж/б, ХХХ, БХХ, NH ₄ , NO ₂ , NO ₃ , N-нийт, P- эрд	Ахуйн бохир усны цооногт Хаягдлын далан	Жилд 2 удаа	180,000	MNS (ISO) 5667- 10:2001 “Усны чанар-дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж: pH,, чийгшил, ялзмаг, NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅	Үйлдвэрийн бүс Мод тарих талбай Хаягдлын далан	Жилд 2 удаа	411,000	MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж: Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr	Кемп Хог хаягдлын цэг Засварын газар Химийн үлдэгдэл цуглуулах Хүдэр жигдрүүлэх талбай Баяжуулах үйлдвэр ШТС	Жилд 2 удаа 7 цэгт	180,000	MNS 6561:2011 ариутгах татуургад нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага.
Ургамал				

Ургамлын зүйлийн бүрдэл, ургамлын тусгаг бүрхэц, арви, 1 м2 талбайгаас газрын дээрх биомасс авах	Үйлдвэрийн талбай орчимд 1 цэгт, Ногоон байгууламж байгуулсан талбай зам дагууд 1 цэгт,	Жилд 1 удаа	300,000	
Дуу чимээ				
Дуу чимээний түвшинг хэмжих	2 цэгт	Жилд 2 удаа	ҮАЗ	
Нийт зардал:			5,500.0 төг	

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Зардал /төг/	Хариуцсан албан тушаалтан
1	Газар, ус, агаар бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах	Гэрээний дүнгээр		Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч
2	Баяжуулах үйлдвэрийн ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	Жилд 1 удаа	500,000	Хүний нөөцийн мэргэжилтэн
3	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх	-		MNS 4219-94
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын ажлын хувцас, багаж хэрэгслээр бүрэн хангах	Жилд 2 удаа өвөл зун	ҮАЗ	ХАБЭА
Нийт зардал			8,500.0	

12. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах ажилтан
1	БОУАӨЯ-д	Цахим хэлбэрээр	2025 оны БОМТ-ний биелэлтийн хүрээнд хийсэн ажил	2025 оны 4-р улирал	-	Байгаль орчны мэргэжилтэн
2	Орон нутгийн байгаль орчны байцаагч болон багийн иргэд	Бичгэн тайлан		2025 оны 4-р улирал	100,000	Байгаль орчны мэргэжилтэн
3	Аймгийн байгаль орчны газарт	Шинжээчийн дүнгээр баталгаажна		2025 оны 4-р улирал	100,000	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал				500.0		

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	Зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	20 000 000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15 500 000
3	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	7 821 300
5	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Түүх соелын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Дүйлцүүлэн хамгаалах арга хэмжээ	20 000 000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5 500 000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	8 500 000
9	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	500 000
Нийт		77 8213 00 төг